



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингисийн дүүрэг, Улаанбаатар хот, 15160


Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.06.30 № 4/167

таний 2025.05.27 ны № 39 -т

Г ГОВЬСУМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ <sup>Т</sup>  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА Б.МӨНХ-ЭРДЭНЭ  
ТАНАА

“Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоох тухай” Говьсүмбэр аймгийн Баянтал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7290 дугаарт бүртгэснийг үүгээр хүргүүлэв.



151602514  
A5.файл.2025



Захиргааны хэм хөмжээний  
актын улсын нэгдсэн бүртгээд  
2025 оны 06 сарын 27-ны  
одрийн дугаарт бүртгээ.

ГОВСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 06

Баянтал сум

Энгийн хог хаягдлын үйлчилгээний  
хураамжийг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн "Аргачлал батлах тухай" 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Иргэд; аж ахуйн нэгж, байгууллагыг ахуйн хог хаягдлаа ангилан ялгадаг хэлбэрт шилжүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах, ачиж тээвэрлэх зарим чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх боломжийг судлах, хог хаягдлын хураамж төлдөг аж ахуйн нэгж, айл өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, түр суугч айл өрхийг тогтоон хогны хураамжийг бүрэн төвлөрүүлэхийг сумын Засаг дарга (Э.Баттулга)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоох тухай" 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МӨНХ-ЭРДЭНЭ

